

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Монголын төмөр зам” ТӨХК үүсгэн байгуулагдсан цагаас нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Он сар	Хийгдсэн ажил
2013-2018	Монгол Улсын Зам, тээврийн яам болон Бээжингийн Зам, харилцааны их сургууль 2012 оны 9 сарын 28-нд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “МТЗ” ТӨХК тус сургуульд 13 оюутан суралцуулах гэрээ байгуулсан. Эдгээр оюутнуудаас 1 оюутан суралцаж байгаа бөгөөд 12 оюутан суралцан төгсөж, төгсөгчдийг компанийн зүгээс ажлын байраар хангах зорилгоор дадлагажуулж байна.
2014.05.02	“Бүх нийтийн мод тарих өдөр” үндэсний хөтөлбөрийн хүрээнд компанийн хамт олон Чингэлтэй дүүргийн 5 дугаар цэцэрлэгийн хашаанд 30 монос суулгаж, мод усалгааны багаж, материалуудыг хүлээлгэн өгсөн.
2015,03	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд төмөр замын барилгын газар шорооны ажил гүйцэтгэх явцад трассын дагуу буюу Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах малчин айл өрхүүдэд нийт 16 худгийг Туслан гүйцэтгэгч компанийн тусламжтайгаар гаргаж өгсөн.
2015.06.14	“Дэлхийн донорын өдөр” аяны хүрээнд ажилтнууд сайн дураар цусаа хандивласан.
2016.12.22	Зам, тээвэр хөгжлийн яамнаас санаачилсан “Малчдад туслах аян”-ы хүрээнд ажилтан бүрээс хандив цуглуулж, 472.000 төгрөгийн туслалцаа үзүүлсэн.
2016.03	“УБТЗ” ХНН-ийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус сургуулийн 20 оюутныг БНСУ-д 3 сарын хугацаанд мэргэжлийн дадлага хийлгэсэн.
2017.02.08	“Эх орны төлөө” Засгийн газрын хөгжилд оруулах хувь нэмэр хандивын аянд нэгдэж нийт ажилтнууд нэг өдрийн цалин болох нийт 6.076.190 төгрөгийг хандивласан.
2017.05.05	“Үндэсний мод тарих өдөр” компанийн хамт олон Хан-Уул дүүргийн 130 дугаар сургуулийн хашаанд “Тэхийн шээг, Агч, Хайлаас” зэрэг нэр төрлийн 400 гаруй модыг тарьж, сургуулийн захиргаанд мод усалгааны багаж, материалуудыг хүлээлгэн өгсөн.
2017.11.25	“МТЗ” ТӨХК-ийн Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрших Төмөртэй өртөөний ажилчдад зориулсан 23 айлын орон сууц барьж, ашиглалтад оруулав.
2018.05.16	“УБТЗ” ХНН-ийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын бааз технологийг сайжруулж, дэмжин ажиллах зорилгоор 5ш иж бүрэн компьютерийг бэлэглэв.
2018,05	.”Үндэсний мод тарих өдөр” хөтөлбөрийн хүрээнд ХУД-ийн 32-р дунд сургуульд 2000ш модны суулгац хандивласан.

2018.08.14	“УБТЗ” ХНН-т байгалийн давагдашгүй нөхцөл байдлын улмаас техникийн осол гэмтэл гарсан бөгөөд “МТЗ” ТӨХК-ийн хамт олны зүгээс сэтгэл санаа болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр нийт ажилтнууд нэг өдрийн цалин болох нийт 8,500.000 төгрөгийг хандивлав.
2018.08.15	“МТЗ” ТӨХК-ийн Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрших Төмөртэй өртөөний ажлын хэрэгцээнд зориулж “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр”-ээс “ажлын бээлий”-г тогтмол худалдан авах гэрээ байгуулав.
2018.10.28	Гүйцэтгэх захирлын Б/183 тоот тусламж үзүүлэх тухай тушаалаар компанийн нийт гэр хороололд амьдардаг ажилчдад түлээ нүүрс бэлтгэх өвөлжилтийн бэлтгэлд зориулан нэг удаагийн мөнгөн буцалтгүй тусламж үзүүлэв.